



ХҮҮХЭД БҮР ЦЭЦЭРЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий нийтэд хүүхдийн эрхэд суурилсан боловсролын орчин, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх замаар тэдний эрхийг хангах, мөн бүх нийтийн боловсролын зорилтод тунхагласан “Бага насны хүүхдэд зориулсан халамж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах” зорилт, үйл ажиллагаа хэрэгжиж, хүүхдийн хөгжлийг багаас нь бүх талаар дэмжих таатай орчин буй болгоход анхаарах боллоо.

Монгол улсын төрөөс цэцэрлэгийн материаллаг орчныг сайжруулах, малчин болон ядуу өрхийн хүүхдүүдийн сурх нөхцөл боломжийг жигд хангахад түлхүү анхаарч байгаа хэдий шийдвэрлэх асуудлууд цэцэрлэгийн түвшинд байсаар байгаад анхаарч хөгжлийн бодлого төлөвлөлтдөө тусган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр хэрэгжүүлж, цэцэрлэгийн чанар, хүртээмж, материаллаг баазыг бүрдүүлнэ, ажилчдынхаа хүүхдүүдэд зориулсан “Байгууллагын цэцэрлэг”-ийг төрөөс бодлогоор дэмжинэ зэрэг багц зорилтууд дэвшүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших боломжийг бүрдүүлж, хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Хүүхэд бүр цэцэрлэгт” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2018-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээний сургуулийн өмнөх боловсролд хамрагдах 8866 хүүхдээс төрийн өмчийн 32 цэцэрлэгт 6418 хүүхэд, хувийн хэвшлийн 13 цэцэрлэгт 561, хувилбарт сургалтаар 708 хүүхэд, нийт 6979 хүүхэд хамрагдаж байна. Мөн хүүхэд харах үйлчилгээний 26 салбарт 146 хүүхэд хамрагдаж хамралтын хувь 80,3 хувь нь хамрагдаж байна.

Аймгийн хэмжээнд 4000 ор бүхий цэцэрлэгийн барилга ашиглагдаж нийт 5710 хүүхэд хамруулж байгаа нь хүчин чадлаасаа 1710 хүүхдээр илүү хүүхэд хамруулан зарим цэцэрлэгүүдэд ачаалал ихэссэн нь үйл ажиллагааны чанарт сөргөөр нөлөөж байна.

Жаргалант суманд ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн нийт 2565 ор бүхий 29 цэцэрлэгт 3545 хүүхэд, хөдөөгийн сумдын хэмжээнд 2055 ор бүхий 17 цэцэрлэгүүдэд 2414 хүүхэд хамрагдаж хүчин чадлаасаа хэтрэлттэй ажиллаж байгаагийн ихэнх нь Жаргалант сумын 7,9,10 дугаар цэцэрлэг, Булган, Үенч, Алтай, Манхан сумдын цэцэрлэгүүд байна.

Аймгийн төвд хүүхдийн хамралт хангалттай байгаа хэдий ч хөдөөгийн сумдын хамралт 62.0 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд СӨБ –д хамрагдах 8866, Жаргалант суманд байгаа 3153 хүүхэд болон хөдөө сумдаас түр оршин суугчдын тус суманд бүртгэлгүй хүүхдүүдээс 2975 нь аймгийн төрийн цэцэрлэгт, 561 хүүхэд нь хувийн цэцэрлэгт хамрагдаж, хөдөө сумдад СӨБ–ийн үйлчилгээнд хамрагдах 5713 хүүхдээс цэцэрлэгийн өдрийн бүлгээр 2768, хувийн цэцэрлэгт 24, хувилбарт сургалтад 708, хүүхэд харах үйлчилгээнд 89 хүүхэд нийт 3589 хүүхэд буюу 62.0 хувь нь хамрагдаж байна. Төв суурин газрын хүүхдүүдийн хамран сургалтыг нэмэгдүүлэхэд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 7 цэцэрлэгийг шинээр барьж, 5 цэцэрлэгийг өргөтгөн цэцэрлэгийн орны тоог 450-иар нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэ зорилт арга хэмжээ хэрэгжсэнээр суурин газруудын цэцэрлэгийн ачааллыг бууруулж, СӨБ –ын хамралт 0,5-1.0 хувиар нэмэгдэхээр байна.

СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа 2124 хүүхдийн 1500 нь 16 сумын 53 багт амьдарч байгаа хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүд байна. Эдгээр хүүхдийг СӨБ – д хамруулах боломж нь хувилбарт сургалт юм.

Өнөөгийн байдлаар СӨБ-д 53 гэр цэцэрлэг ашиглагдаж байгаагийн 40 нь багуудад зуны улиралд ажиллахаар байна. Гэвч гэр цэцэрлэгүүдээс 1998-2000 онд нийлүүлсэн 20 гэр нь элэгдэлд орж сургалтад ашиглах боломжгүй болсон байна. Хөтөлбөрийн хүрээнд багуудад ажиллах 40 гэр цэцэрлэгийг нэмж хөдөөгийн бүх багуудад гэр цэцэрлэг ажиллах боломжийг бүрдүүлснээр СӨБ

хамрагдаж чадахгүй байгаа малчин өрхийн 800-900 хүүхдийг нэмж хамруулснаар СӨБ-ын хамралтын дундаж 92.0 хувьд хүрэхээр байна.

Үлдсэн хүүхдийг явуулын багшийн сургалтад хамруулж 5 настай хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулж сургуульд бэлтгэнэ.

СӨБ-ын хамралтыг нэмэгдүүлж үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах шаардлага хэрэгцээг үндэс болгон “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго.

Сургуулийн өмнөх боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

- 3.1.Хувилбарт сургалтыг орон нутгийн онцлогт уялдуулан өргөжүүлнэ.
- 3.2 .Сургуулийн өмнөх боловсролын хамралтыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулна.
- 3.3 .Сургуулийн өмнөх боловсролд орон нутгийн удирдлага, эцэг эх олон нийт, байгууллага хамт олны оролцоо хандлагыг нэмэгдүүлнэ.

Дөрөв: Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1-ийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулна.

- 1.1.Гэр цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж хөдөөгийн бүх багуудад гэр цэцэрлэг ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 1.2.Цэцэрлэгүүдийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэж, ээлжийн бүлгийн тоог нэмэгдүүлнэ.

1.3.Явуулын багш бэлтгэн, алслагдсан нутгийн өрхийн хүүхдүүдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах.

Зорилт 2-ын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулна.

- 2.1.Жаргалант сумын Тахилт, Цамбагарав, Наран, Бугат багуудад, Булган, Мянгад, Ховд суманд шинээр цэцэрлэг барих.
- 2.2.Манхан, Алтай, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан, Цэцэг сумын цэцэрлэгийн барилга засварлах, Жаргалант сумын 7,9,10 цэцэрлэгийн өргөтгөл хийх.

2.3. Цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх.

Зорилт 3 –ын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулна.

3.1. Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн “Хувилбарт сургалтын хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлэх.

3.2. Аймгийн хэмжээнд орон нутгийн удирдлага, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш эцэг эхийг оролцуулсан “Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахад олон талын оролцоог өргөжүүлэх боломж” чуулган зохион байгуулах.

3.3. Байгууллагын дэргэд цэцэрлэг ажиллуулах зөвлөмж гарган, хувийн болон байгууллагын дэргэдэх цэцэрлэгийг дэмжин арга зүйгээр ханган ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтээр тооцно.

Д.Д	Зохион байгуулах арга хэмжээ	2018 оны		Хүрэх үр дүн
		түвшин	2020	
1.	Гэр цэцэрлэгийн тоо	53	90	
2.	Шинээр нэмсэн бүлгийн тоо	232	260	
3.	Ажлын байртай болсон багшийн тоо	22	50	
4.	Сургалтын хэрэглэгдэхүүний хангамж /хувь/	60.0	90.0	
5.	Туршлага түгээсэн багшийн тоо	50	150	
6.	Хувилбарт сургалтын хөтөлбөр	10	18	
7.	Сургуульд бэлтгэх ажлын чанар /хувь/	70.0	90.0	
8.	Хүүхдийн тоо /малчдын /	1200	2200	
9.	Сургалтад хамрагдсан эцэг эхийн тоо	100	2500	
10.	Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг /сая.төгрөг/	50.0	100.0	
11.	Зөвлөн тусалсан , зөвлөх багш нарын тоо	53	90	
12.	СӨБ-ын хамралтын хувь	81,9	92.0	
13.	Сургуульд элсэх насны хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулах /хувь/	85.0	100.0	

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр

2018-2020 онуудад хэрэгжинэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1.Аймгийн Засаг даргын Тамгын Газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтаар ханган жил бүр биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг байнгын мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг аймгийн Боловсрол соёл, урлагийн газар хүлээнэ.

6.3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, сумын орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үүргийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

6.4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хичээлийн жил бүрийн эхэнд боловсруулан цэцэрлэгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг тайлагнан, иргэд болон иргэний нийгмийн төлөөллийн оролцоог хангаж ажиллах үүргийг цэцэрлэгийн удирдлага хүлээнэ.

6.5.Боловсролын байгууллагын удирдлага, багш, ажилтнууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, эцэг эх, олон нийттэй хамтран ажиллана.

Долоо. Санхүүжилт

7.1.Улсын төсөв.

7.2.Орон нутгийн төсөв.

7.3.Олон улсын төсөл, хөтөлбөр.

7.4.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусlamж

Найм. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Зорилго	Хугацаа /Жил, он/	Хариуцах байгууллага	Төсөв /сая.төгрөг/		
					Улсын төсөв	ОНХС	Бусад
Нэг: Хувилбарт сургалтыг орон нутгийн онцлогт уялдуулан өргөжүүлнэ.							
1.1.	1.1. Гэр цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж хөдөөгийн бүх багуудад гэр худалдан авч үйлчилгээг өргөжүүлэх.	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх	2018- 2020	НБХХ БСУГ	10.0	30.0	42.0
1.2.	1.2. Цэцэрлэгүүдийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэж, ээлжийн бүлгийн тоог нэмэгдүүлнэ.		2018- 2019		5.0		10.0
1.3.	1.3. Явуулын багш бэлтгэн, алслагдсан нутгийн өрхийн хүүхдүүдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулна.				10.0	15.0	7.0
Хоёр: Сургуулийн өмнөх боловсролын хамралтыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулна.							
2.1	Жаргалант сумын Тахилт, Цамбагарав, Наран, Бугат багуудад, Булган, Мянгад, Ховд суманд шинээр цэцэрлэг барих	Сургуулийн өмнөх боловсролы н хүүхдийн суралцах орчин	2018- 2020	НБХХ БСУГ цэцэрлэг			
2.2	Манхан, Алтай, Эрдэнэбүрэн, Мөнххайрхан, Цэцэг сумын цэцэрлэгийн барилга засварлах, Жаргалант сумын 7,9,10 дугаар цэцэрлэгийн өргөтгөл хийх						
2.3	Цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх						

		нөхцөл сайжруулах			5.0	40.0	23.0
Гурав: Сургуулийн өмнөх боловсролд орон нутгийн удирдлага, эцэг эх олон нийт, байгууллага хамт олны оролцоо, хандлагыг нэмэгдүүлнэ							
3.1.	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн “Хувилбарт сургалтын хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлэх		2019				5.0
3.2.	Аймгийн хэмжээнд орон нутгийн удирдлага, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш эцэг эхийг оролцуулсан “Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахад олон талын оролцоог өргөжүүлэх боломж” чуулган зохион байгуулах	СӨБ-ын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх	2020	ЗДТГ БСҮГ		5.0	3.0
3.3.	Байгууллагын дэргэд цэцэрлэг ажиллуулах зөвлөмж гарган, хувийн болон байгууллагын дэргэдэх цэцэрлэгийг дэмжин арга зүйгээр ханган ажиллах		2019				
	Нийт /221.0 сая төгрөг/				30.0	91.0	100.0

.....оо.....